



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 13 өдөр

Дугаар A/223

Эрдэнэт

Г “Эмч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны
арга хэмжээний төлөвлөгөө, төсвийг
батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.1, 11.1.2, 11.1.3, 11.1.7, 11.2.4, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит VI хуралдааны 06/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Эмч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны арга хэмжээний төлөвлөгөө, төсвийг хавсралтаар баталсугай.

2.Зардалд шаардагдах 60,000,000 (жаран сая) төгрөгийг Төсөл хөтөлбөрийн зардлын “Эмч хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал”-аас гаргаж, батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Бямбацэцэг)-т зөвшөөрсүгэй.

3.Батлагдсан төсвийг үр дүнтэй зарцуулж, тайлagnаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч (Д.Сүхээ)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (А.Бумансор)-д даалгасугай.



“ЭМЧ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2022 ОНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Санхүүжилтийн эх үүсвэр
Зорилт 1. Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадвар, төлөвшил, ёс зүй, хариуцлага, хандлагыг нэмэгдүүлэх							
1	Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон магистр, докторын сургалтад төлөвлөлтийн дагуу хамруулах	Төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	73%	75%	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд	Улс болон орон нутгийн төсөв Тухайн байгууллагын төсөв
2	Орон нутагт нэн шаардлагатай байгаа мэргэшүүлэх сургалтад хамрагдахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж дэмжлэг үзүүлэх	Нэн шаардлагатай мэргэжил эзэмшижсан эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	75%	80%	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд	3,0 сая төгрөг Орон нутгийн төсвөөс
3	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд судалгаа шинжилгээний ажил хийх, өгүүлэл нийтлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх /эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах/	Судалгаа шинжилгээний ажлын тоо, ур дүн	3	4	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд, Хандивлагч байгууллага	23,0 сая төгрөг Орон нутгийн төсвөөс
		Судалгаа, шинжилгээний ажил хийсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	17,5%	18%			
4	Мэргэжлийн зэрэг ахиулахад дэмжлэг үзүүлэх	Мэргэжлийн зэрэгтэй эмчийн эзлэх хувь	23%	24%	ЭМГ, ЭМБ-үүд	Эрүүл мэндийн байгууллагууд	Тухайн байгууллагын төсөв
5	Өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлэх, магистр, докторт суралцахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж дэмжлэг үзүүлэх	Боловсролын зэрэгтэй эмчийн хувь	11,1%	12%	ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд	ЗДТГ, Гадаад дотоодын их дээд сургууль, институт	5,0 сая төгрөг Орон нутгийн төсвөөс
6	Гадаад улсад бэлтгэгдсэн эмч, мэргэжилтэн өөрийн мэдлэг, туршлагаа түгээн дэлгэрүүлэхийг дэмжих	Мэдлэг, туршлагаа дэлгэрүүлсэн эмч, мэргэжилтний тоо	0	2	ЭМГ, ЗДТГ	Эрүүл мэндийн байгууллагууд	Орон нутгийн төсөв, төрийн болон хувийн

							хэвшлийн ЭМБ-үуд
7	Эмч, эмнэлгийн мэргэжилтний гадаад хэлний мэдлэгийн түвшнийг үе шаттайгаар дээшлүүлэх, суралцахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж дэмжлэг үзүүлэх	Гадаад хэлний мэдлэгийн түвшин, дээшлүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	18,6%	19%	ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд	ЗДТГ	2,0 сая төгрөг Орон нутгийн төсвөөс
8	Эмнэлгийн практик шинэ төрлийн эмчилгээ нэвтрүүлэх	Эмнэлгийн практикт нэвтрүүлсэн шинэ төрлийн эмчилгээ үйлчилгээний тоо	2	3	Эрүүл мэндийн байгууллагууд	ЭМГ	Бусад эх үүсвэр
9	Орчин үеийн дэвшилтэт технологи ашиглах, хэрэглэх аргад суралцахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, дэмжлэг үзүүлэх	Суралцсан эрүүл мэндийн ажилтны тоо	8	10	ЭМГ	ЗДТГ, ЭМБ-үуд	2,0 сая төгрөг Орон нутгийн төсвөөс
10	Эрүүл мэндийн байгууллагууд цахим тоног төхөөрөмж ашиглан суралцах, эмчилгээ оношилгоонд ашиглах боломж бүрдүүлэх	Цахим тоног төхөөрөмжөөр хангагдсан байгууллагын тоо	1	5	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд	Бусад эх үүсвэр
11	Гадаад, дотоодын эмч нартай ажил мэргэжлийн туршлага солилцох, ажлын байр сэлгэн ажиллах нэхцэлийг бий болгох	Сэлгэн ажилласан эмчийн тоо	-	3	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд, Хандивлагч орнууд	4,0 сая төгрөг Орон нутгийн төсвөөс
12	Нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөлдөх уулзалтыг жил бүр зохион байгуулах	Уулзалт, зөвлөгөөний тоо, үр дүн	-	1	ЭМГ	Эрүүл мэндийн байгууллагууд, ЗДТГ	Орон нутгийн төсөв
13	Эрүүл мэндийн ажилтны ёс зүйг хувь хүний хандлагад тулгуурлан төлөвшүүлэх сургалтыг зохион байгуулах	Ёс зүйн зөрчил гаралгүй байх	-	-	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороо	ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд	2,0 сая төгрөг Орон нутгийн төсвөөс
14	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, байгууллагын хөгжил удирдлага төлөвлөлт зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор үйлчлүүлэгчид, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг авах, судалгааны дунг үндэслэн арга хэмжээг зохион байгуулах	Сэтгэл ханамжийн судалгаа хийсэн тоо, үр дүн	-	85%-иас дээш	“Залуу эмч нарын холбоо” ТББ	ЗДТГ, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг	2,0 сая төгрөг Орон нутгийн төсвөөс
15	Эрүүл мэндийн байгууллагуудын менежментийг сайжруулах, манлайллыг	Сургалтад хамрагдсан байгууллагын тоо	2	4	ЭМГ	Төрийн албаны салбар	Улс болон орон нутгийн төсөв

	хөгжүүлэх чиглэлээр сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах					зөвлөл, Удирдлагын академи, Төрийн бус байгууллага	
--	--	--	--	--	--	--	--

Зорилт 2. Хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах, тогтвортой ажиллах боломжийг бурдуулна.

16	Эрүүл мэндийн ажилтнуудыг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах /400 Ажилчдын насны бүлэгт тохируулан шаардлагатай хавдрын маркерүүдийг үзэх/	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан ажилтны хувь, эмчлэн эрүүлжүүлсэн ажлын үр дүн	85%	87%	Эрүүл мэндийн байгууллагууд	НБХ ЭМГ Төрийн болон хувийн хэвшлийн ЭМБ Эрүүл мэндийн даатгалын сан	10,0 сая төгрөг Орон нутгийн төсвөөс
17	Эрүүл мэндийн салбарын ажилчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөөх чийрэгжүүлэлт болон амрах өрөөг засаж, тохижуулах	Тохижуулсан танхимын тоо	-	1	Эрүүл мэндийн байгууллагууд	ЭМГ, ЗДТГ, Хандивлагч байгууллага	Төрийн болон хувийн хэвшлийн ЭМБ-үүд
18	Гэр болон түрээсийн орон сууцанд хамруулах	Хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо	1	3	ЭМГ	ЭМГ, ЗДТГ, Баян-Өндөр сумын ЗДТГ	Олон улсын төсөл хөтөлбөр
19	Ахмад эмч, сувилагч нарыг мэргэжлийн сургалтад хамруулж цаг үеийн мэдээллээр хангтан хамтран эрүүл мэндийн арга хэмжээ зохион байгуулах	Сургалт мэдээлэлд хамрагдсан хувь	10%	15%	“Буурлын чагнуур” ТББ	ЭМГ, ЗДТГ	1,0 сая төгрөг Орон нутгийн төсвөөс
20	Нийгмийн ноцтой байдлын үед ялангуяа ковидын цар тахлын үеийн хариу арга хэмжээнд ажиллаж буй эмч, эмнэлгийн ажиллагдын нийгмийн баталгааг хангах дэмжлэг үзүүлэх	Нийгмийн ноцтой байдлын үед ялангуяа ковидын цар тахлын үеийн хариу арга хэмжээнд ажиллаж буй эмч, эмнэлгийн ажиллагдын дэмжлэгт хамрагдсан хувь	25%	30%	ЭМГ	ЭМГ, ЗДТГ ЭМБ-үүд	5,0 сая төгрөг Орон нутгийн төсвөөс
21	Жил бүр аймгийн “Тэргүүний эрүүл мэндийн ажилтан”-ийг сонгон шалгаруулж, урамшуулдаг байх	Шалгарсан эрүүл мэндийн ажилтны тоо	-	1	ЭМГ	ЭМГ, ЗДТГ ЭМБ-үүд	1,0 сая төгрөг Орон нутгийн төсвөөс
Нийт төсөв							60,0 сая төгрөг